



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/34.

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтын 3.4.1.6, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.6, “Улаанбаатар хотын аялал жуулчлал-2015” хөтөлбөрийн 4.1.16 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гадаадын иргэд, жуулчдыг гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хэрэг зөрчлийг шуурхай шийдвэрлэх зорилгоор нийслэлийн Цагдаагийн газрын дэргэд олон нийтийн цагдаад түшиглэсэн жуулчны цагдаагийн бүтцийг бий болгох ажлын хүрээнд “Жуулчинд ээлтэй оюутан цагдаа” сэдэвт сургалтыг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалтын төсөв болох 450,000 / дөрвөн зуун тавин мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.


3. Сургалтыг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/, Жуулчны аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /М.Баасандорж/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
 2014 оны 06 сарын 02 ний өдрийн
 А/34 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



**“ЖУУЛЧИНД ЭЭЛТЭЙ ОЮУТАН ЦАГДАА”
 СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

Зорилго: Гадаадын иргэд жуулчдыг гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хэрэг зөрчлийг шуурхай шийдвэрлэх зорилгоор Нийслэлийн Цагдаагийн газрын дэргэд олон нийтийн цагдаад түшиглэсэн жуулчны цагдаагийн бүтцийг бий болгох ажлын хүрээнд “Жуулчинд ээлтэй оюутан цагдаа”-гаар ажиллах сайн дурын оюутнуудыг чадваржуулах, харилцаа ёс зүй, англи хэлний ярианы анхан шатны мэдлэг олгоход тус сургалтын зорилго оршиж байна.

Сургалтын хөтөлбөр:

Сургалтын нэр	Цаг	Хамрагдах алба хаагч	Сургалтын хэлбэр	Сургалт явуулах багш	Нийт цаг
Иргэд олон нийттэй харилцах харилцааны тухай ойлголт, зөв боловсон харилцаа	2	Хөтөлбөрт оролцох оюутнууд	лекц	Сэтгэл зүйчдийн баг	6 цаг
Харилцааны сэтгэл зүй /өөрийгөө илэрхийлэх, бусдад таниулах ойлгуулах чадвар, иргэдтэй харилцах соёл/	2		ярилцлага	Сэтгэл зүйчдийн баг	
Жуулчдын сэтгэл зүйн онцлог, тэдгээртэй харьцах арга зүй	2		ярилцлага	Сэтгэл зүйчдийн баг	
Хүний эрх, үндсэн зарчим, түүнийг хангах баталгаа	4		лекц	СДТ-ийн багш	4 цаг
Гадаадын жуулчидтай харилцах үндсэн хэл, анхаарах асуудал	15		дадлага сургалт	НАЖГ-ын багш	15 цаг
Зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх чадвар, аливаа довтолгооноос бусдыг болон өөрийгөө хамгаалах арга тактикийн талаархи ерөнхий ойлголт	2		лекц	СДТ-ийн сургагч багш	6 цаг
	4		дадлага сургалт		
Захиргааны хариуцлагын тухай хуулийн ойлголт, нийтлэг үндэслэл	2		лекц	СДТ-ийн сургагч багш	6 цаг
Захиргааны зарим зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлага	2		лекц		
Захиргааны зөрчил, түүнийг гэмт хэргээс ялгаж ойлгох нь	2		лекц		

Тусгай хэрэгсэл хэрэглэх ёс зүй, ашиглах чадвар, баримтлах хууль тогтоомж	4		дадлага сургалт	СДТ-ийн багш	4
Мэдээлэл холбооны техник хэрэгсэл ашиглах чадвар, харьцах арга ажиллагаа	4		дадлага сургалт	МШУТөв	4
БҮГД	40 цаг				40 цаг

Хамрах хүрээ: Жуулчны цагдаагаар ажиллах сайн дурын 100 оюутныг хоёр ээлжээр хамруулна. Нэгдүгээр ээлж 2014 оны 07-р сарын 01-05, хоёрдугаар ээлж 07-р сарын 05-10-ны өдрүүдэд зохион байгуулагдана.

Зохион байгуулагч: Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Цагдаагийн газар, Монголын оюутны холбоо.


Хугацаа: 2014 оны 07-р сарын 01-10-ны өдөр зохион байгуулна.

Хүрэх үр дүн: Нийслэлийн Цагдаагийн газрын дэргэд олон нийтийн цагдаад түшиглэсэн жуулчны цагдаагийн бүтэц бий болж, гадаадын иргэд жуулчдыг гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хэрэг зөрчлийг шуурхай шийдвэрлэхэд ахиц гарсан байна.

Хаана болох: Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Мэдээлэл, сурталчилгааны төвийн сургалтын танхимд

Бүртгэх газар: Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дэргэдэх Аялал жуулчлалын мэдээлэл, сурталчилгааны төв (Бага тойруу-15 Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Нийслэлийн Засаг захиргааны 4-р байр хуучнаар Улаанбаатар банкны байрны Баруун хойд талын хаалга) Холбоо барих утас: 70108687, 7014-8687, 99838674, 99013782

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2014 оны 06 сарын 04 ний өдрийн
А/З/ тоот тушаалын хоёрдугаар хавсралт



“ЖУУЛЧИНД ЭЭЛТЭЙ ОЮУТАН ЦАГДАА”
СУРГАЛТЫН ТӨСӨВ

Зардлын төрөл	Нэг цаг /60 минут/	Сургалт зохион байгуулах цаг	Нийт үнэ
Англи хэл, харилцааны соёлын хичээлийн төлбөр /80 оюутан/	30000	15	450,000
Нийт дүн			450,000

ТӨСӨВ ЗОХИОСОН:
НАЖГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Ш.УНДАРМАА

ХЯНАСАН:
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

П.АРИУНАА